




ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 518 ор, амбулаторийн 101 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 111,2 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 42,9 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 7,2 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98,8 хувийг бүрэн хамруулсны дотор Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Цэнхэр сумд 100,0 хувь хамруулсан байна.


Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Оны эхний 4 сард 638 эхээс 647 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оныхоос 1,4 хувиар буюу 29 хүүхдээр илүү байна,

Хүн амын нас баралт 129 гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 39 тохиолдлоор буюу 23,2 хувиар бага байна. Мянган хүнд ноогдох төрөлт 6,9, нас баралт 1,4 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 5,5 промил байна. Нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл гараагүй, нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 8 гарч мянган амьд төрөлтөд 12,4 ногдож

байгаа нь өнгөрсөн оныхоос 14 тохиолдлоор буурсан байна.



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 17 нь буюу 162 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Эрдэнэбулган(34), Ихтамир (31), Эрдэнэмандал (34), Өлзийт(18), Төвшрүүлэх(20) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 29,0 хувь нь салхин цэцгээр, 3,7 хувь нь улаан бурханаар, 41,4 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 12,3 хувь нь сүрьеэгээр, 13,6 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Өнгөрсөн оныхоос халдварт өвчний гаралт 6.4 дахин буюу 876 тохиолдлоор буурсан байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР

5 дугаар сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 1424 ажилгүй хүн байгаагийн 49,5 хувь нь буюу 705 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10,0 мянган хүн тутамд 255 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 17,2 хувиар нэмэгдсэн байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 98,6 хувь нь боловсролтой иргэд

байгаагийн 237 нь дээд, 71 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 991 нь бүрэн болон бүрэн бус дунд, 105 нь бага боловсролтой хүмүүс байна.

4 дүгээр сард ажилгүйчүүдийн бүртгэлд 751 хүн шинээр бүртгүүлж, 957 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болсон байна. Харин 182 хүн ажилд орсон байна.

Оны эхний 4 сард аймгийн дүнгээр 79 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар үзвэл Эрдэнэбулган сум 47, Хангай сум 23, Чулуут сум 7, Ихтамир, Хотонт сумд тус бүр 1 ажлын байрыг бий болгожээ.



НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 4 сард 15,7 тэрбум төг, зарлага 15,1 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 1384,3 сая төг буюу 9,6 хувь, зарлага 1530,0 сая төг буюу 11,3 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 1384,3 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 9,0 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 15,7 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 2,4 дахин өссөн нь нөлөөлсөн байна.


Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 11,3 хувиар өсөхөд тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэнд, ажилгүйдлийн даатгалын сангууд өссөн нь нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 13,0 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 467,5 сая төгрөгийг олгосон байна.

Оны эхний 4 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 18,3 мянган хүнд 3753,5 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 51,7 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон

халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт 48,3 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 55,7 хувийг халамжийн тэтгэврээр, 29,6 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 14,7 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц



ГЭМТ ХЭРЭГ


Аймгийн хэмжээгээр 156 холбогдогч бүхий 177 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 57, өмчлөх эрхийн эсрэг 87, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний

аюулгүй байдлын эсрэг 14, байгаль хамгаалах журмын эсрэг 3, бусад 16 хэрэг гарсан байна.

Гэмт хэргийн улмаас 15 хүн нас барж, 66 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 497,6 сая төгрөгийн хохирол


учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 9,0 хувийг бүлэглэж 29,9 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 357 хүнийг албадан саатуулж 64 хүнийг баривчилсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 0,6 хувиар буюу 1 тохиолдлоор нэмэгдсэний дотор хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 16,3 хувиар буюу 8 тохиолдлоор өсч харин өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 21,6 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 4 сарын байдлаар




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2017 оны эхний 4 сард аймгийн төсөвт 6278,1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 8456,6 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 134,7 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 1404,3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 3582,8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 255,1 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг Ихтамир, Хангай, Тариат, Өндөрүлаан, Жаргалант, Цэцэрлэг, Батцэнгэл, Өлзийт, Цэнхэр, Хотонт, Төвшрүүлэх, Булган, Эрдэнэбулган, Цахир сумд 115,0 хувиас 46 дахин биелүүлсэн байна. Харин Чулуут, Хайрхан, Өгийннуур, Хашаат сумд 8,6-38,1 хувиар тасалсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар




Орлогыг нэр төрлөөр нь үзвэл хог хаягдлын хураамж, газрын төлбөр, түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөрөөс бусад нэрийн орлогуудыг 110,0 хувиас 9,4 дахин биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогын 57,6 хувийг тусламжийн орлогоор, 15,2 хувийг орлогын албан татвараар, 1,1 хувийг өмчийн татвараар, 1,7 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 19,2 хувийг бусад албан татвараар, 5,2 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 68,3 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 225,3 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 12,8 сая төгрөг бүгд 306,4 сая төгрөгийг шилжүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 19109,1 сая төгрөг байгаагийн 52,5 хувийг цалин хөлсөнд, 5,6 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 41,9 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 30,4 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээнд, 59,0 хувийг боловсролын салбарт, 9,7 хувийг эрүүл мэндийн салбарт, 0,6 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0,3 хувийг бусад салбарт зарцууллаа.

Орон нутгийн төсвийн байгууллагын нийт зарлагын бүтэц, хувиар




МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 12,3 тэрбум төгрөгийг авч 7,4 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 4 сард банкууд 21,3 мянган иргэд, аж ахуй нэгжид 40,8 тэрбум төгрөгийн зээл олгосны дотор 14 хүнд 600,0 сая төгрөгийн орон сууцны зээл олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 4 сарын байдлаар сая.төг



Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 32,9 хувиар өсч анхаарал хандуулах зээлийн хэмжээ 13,8 хувиар багаслаа. Харин чанаргүй зээлийн хэмжээ 59,0 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 4 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0,3 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 7,6 хувиар, 2010 оны 12-р сарынхаас 2 дахин тус тус өссөн байна.

Өнгөрсөн 3 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 214 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 6,1 хувийнх нь өсч, 1,4 хувийнх нь үнэ буурч, 92,5 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас манжин байцаа, луувангийн үнэ 18,2 хувиар буурч харин адуу ямаа, хонины мах, хорхой ааруул, сармис, шүдний оо, гар нүүрийн саван, ариун цэврийн цаас, эмэгтэй хүүхдийн трико зэргийн үнэ 2,0 – 13,6 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 49,5 хувийнх нь буюу 106 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 5,1 хувийнх нь буюу 11 нэрийн барааны үнэ буурч, 45,4 хувийнх нь үнэ тогтвортой байна.

Өнгөрсөн оны мөн үеийнхээс төмс, өндөг, хорхой ааруул, А-92 бензин, дизелийн түлш, флаш дискний үнэ 1,8 – 15,1 хувиар буурч, харин хатуу чихэр, цай, давс, тамхи, ундаа, шар,цагаан будаа, гурил, алим, элсэн чихэр, сурагчийн цүнх, сурагчийн дөрвөлжин шугамтай дэвтэр, лаа,трико 4-5 настай охидын, хүүхдийн пүүз,эрэгтэй эмэгтэй хүний гадуур, дотуур хувцас, гутал, ботинк, даавуу, гэр ахуйн хэрэгсэл, тавилга, оо, саван,тамхи, түлшний мод зэрэг барааны үнэ 1,3- 76,9 хувиар нэмэгдсэн байна.




ХӨДӨӨ АЖ АХУЙ

5 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний хээлтэгч малын 74,4 хувь нь буюу 1590,3 мянган эх мал төллөж гарсан төлийн 96,3 хувь нь буюу 1531,0 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботгоны 96,5 хувь, унаганы 95,8 хувь, тугалын 96,5 хувь, хурганы 97,2 хувь, ишигний 94,3 хувь нь бойжиж байна.

Сумдаас Өгийнуур, Хашаат, Төвшрүүлэх, Өлзийт, Хангай сумд гарсан төлөө 99,0-99,7 хувиар бойжуулж байна.


Өнгөрсөн оны мөн үеийнхээс аймгийн дүнгээр төллөсөн эх мал 28,2 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 26,7 хувиар илүү байна.



5 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний мал 98,7 хувиар онд орж оны эхний малын 1,3 хувь буюу 64,4 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 5,9 хувийг адуу, 12,4 хувийг үхэр, 46,2 хувийг хонь, 35,5 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Сумдаас Хотонт, Эрдэнэбулган, Жаргалант, Цэцэрлэг сумдын оны эхний малын 2,1-3,8 хувь нь, бусад сумдын малын 0,3-1,6 хувь нь хорогдсон дүнтэй байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



2017 онд манай аймаг ойгоос 100,8 мянган м3 галын түлээ, 12,7 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 113,5 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 4 сард 23,9 мянган м3 галын түлээ, 1,9 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 25,8 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 78,6 сая төгрөг төсвийн орлогод оруулж, ойн зөрчилд 1,2 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна.




АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2017 оны эхний 4 сард оны үнээр 2,8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан нь өнгөрсөн оныхоос 65,7 хувиар илүү байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 1058,8 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 25,5 хувиар илүү байна.

Нийт үйлдвэрлэлтийн 4,0 хувийг хүнс ундааны, 0,6 хувийг хэвлэлийн, 77,1 хувийг дулааны эрчим хүчний, 11,6 хувийг усан хангамж, 1,6 хувийг модон эдлэлийн, 4,9 хувийг гутал хувцасны, 0,2 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, түгээсэн цэвэр ус, дулаан, монгол болон савхин гутал, дээл, гэрийн модон тавилгын үйлдвэрлэлт 0,2-40,9 хувиар нэмэгдлээ. Харин бууз, хэрчсэн гурил, хүснэгт маягт үйлдвэрлэлийн хэмжээ 8,1 – 38,5 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт, бүтэц, хувиар



Тээврийн байгууллагууд 16,5 мянган зорчигч, 1,9 мянган тонн ачаа тээвэрлэн 7,6 сая хүн км, 0,8 сая ткм ажил гүйцэтгэн 72,2 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлтийн хэмжээ 22,2-22,9 хувиар нэмэгдлээ.

Холбооны байгууллагууд 505 телефон цэг улс, хот хоорондын телефон, интернет, телевизийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 100,6 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5,9 хувиар өссөн байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

4 дүгээр сард агаарын дундаж температур 1,6-аас 8,3 хэм байсан бөгөөд хамгийн их дулаан Өлзийт, Өгийнуур, Батцэнгэл, Хашаат сумдад 23,0-өөс 24,0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Хангай, Тариат, Өндөрүлаан сумдад –10,0-ээс –12,0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Энэ сард Эрдэнэбулган, Хангай, Цэцэрлэг, Батцэнгэл сумдын нутгаар 5,5 – 14,8 мм цас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Өндөрүлаан, Хайрхан, Цахир сумдад 0,7-1,1 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

Статистикийн хэлтэс
2017.05.10